МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
Т О Г Т О О Л

2015 оны 06 сарын 24 өдөр Дугаар 286 Улаанбаатар хот

"Улаанбаатар Дулааны Сүлжээ" ТӨХК-ийн
үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 63.1.10, Компанийн тухай хуулийн 42 дугаар зүйл, Хорооны 2014 оны 6 дугаар тогтоолоор батлагдсан "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын 20 дахь зүйлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Улаанбаатар Дулааны Сүлжээ" ТӨХК-ийн нийт гаргасан 729,369,708 /Долоон зуун хорин есөн сая гурван зуун жаран есөн мянга долоон зуун найм/ ширхэг энгийн хувьцааг 221,280,101 /хоёр зуун хорин нэгэн сая хоёр зуун наян мянга нэг зуун нэг/ ширхэг энгийн хувьцаагаар нэмэгдүүлж нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий нийт 950,649,809 /есөн зуун тавин сая зургаан зуун дөчин есөн мянга найман зуун ес/ ширхэг хувьцаатай байхаар үнэт цаасны дэлгэрэнгүй бүртгэлд өөрчлөн бүртгэхийг Үнэт цаасны зохицуулалтын газар /Т. Гандулам/, Хөрөнгийн биржийн жагсаалтад бүртгэхийг "Монголын хөрөнгийн бирж" ХК /Ангар/, үнэт цаасны төвлөрсөн хадгаламжид бүртгэхийг "ҮЦТТТХТ" ХХК /Ж. Алдаржавхлан /-д тус тус үүрэг болгосугай.

2. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйл болон Санхүүгийн зохицуулах хорооны 2007 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан "Үнэт цаасны зах зээлийн мэдээллийн нэгдсэн сангийн тухай журам"-д заасан мэдээллийг цаг тухайд нь Санхүүгийн зохицуулах хороонд тогтмол ирүүлж, хууль тогтоомж болон хөрөнгө оруулагчдын өмнө хүлээсэн үүргээ чанд биелүүлэн ажиллахыг "Улаанбаатар Дулааны Сүлжээ" ТӨХК /Р. Хайдав/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Б. Батсэлэнгэ/-нд даалгасугай.

ДАРГА 3. НАРАНТУЯА

000879